

**БНМАУ-ЫН ЗАСГИЙН ГАЗАРТ ЭРХ ОЛГОХ ТУХАЙ ХУУЛЬ ХҮЧИНГҮЙ  
БОЛСОНД ТООЦОХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН АНХНЫ ХЭЛЭЛЦҮҮЛГИЙГ  
ЯВУУЛСАН ТАЛААРХ ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН ХОРООНЫ САНАЛ, ДҮГНЭЛТ**

2026 оны 05 дугаар  
сарын 20-ны өдөр

Улаанбаатар  
хот

**Илтгэгч нь: Улсын Их Хурлын гишүүн Р.Сэддорж**

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлын гишүүн С.Цэнгүүнээс 2025 оны 12 дугаар сарын 30-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн БНМАУ-ын Засгийн газарт эрх олгох тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийн хэлэлцэх эсэх асуудлыг 2026 оны 04 дүгээр сарын 24-ний өдрийн Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаараа хэлэлцэн шийдвэрлэж, төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Эдийн засгийн байнгын хороонд шилжүүлсэн.

Эдийн засгийн байнгын хороос 2026 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн хуралдаанаараа Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлд заасныг баримтлан дээрх хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулж, дараах санал, дүгнэлтийг гарган Та бүхэнд танилцуулж байна.

Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулах үед Улсын Их Хурлын гишүүдээс хуулийн төсөлтэй холбоотой асуулт, хариулт гараагүй бөгөөд Улсын Их Хурлын гишүүн С.Цэнгүүн төслийн дагаж мөрдөх хугацааг 2026 оны 07 дугаар сарын 01-ний өдөр болгож өөрчлөх зарчмын зөрүүтэй санал гаргасныг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

БНМАУ-ын Засгийн газарт эрх олгох тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Эдийн засгийн байнгын хорооны санал, дүгнэлт болон зарчмын зөрүүтэй саналыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Та бүхнээс хүсье.

Анхаарал хандуулсанд баярлалаа.

**ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН  
ХОРООНЫ ДАРГА**

**Р.СЭДДОРЖ**



**БНМАУ-ЫН ЗАСГИЙН ГАЗАРТ ЭРХ ОЛГОХ ТУХАЙ ХУУЛИЙН  
ТӨСЛИЙН ТАЛААРХ ЗАРЧМЫН ЗӨРҮҮТЭЙ САНАЛЫН ТОМЬЁОЛОЛ**

**Нэг. Эдийн засгийн байнгын хороо дэмжсэн санал**

1.Хуулийн төслийн 2 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөх:

“2 дугаар зүйл.Энэ хуулийг 2026 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.”

**Санал гаргасан: Улсын Их Хурлын гишүүн С.Цэнгүүн**

----oOo----